




ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд 4 долоо хоног дараалан өслөө. Томоохон банкуудын хувьцааны ханш өссөнөөр S&P 500 индексийн сагсанд багтдаг санхүүгийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол ус, цахилгаан, дулаан үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна. АНУ-ын Калифорни мужийн умард хэсэгт гарсан гал түймрээс болж "Pacific Gas and Electric" компанийн өр төлбөр нэмэгдэн, улмаар дампуурлаа зарлав.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны хэлэлцээр үргэлжилж байна. Долоо хоногийн эхээр БНХАУ-ын экспортын хэмжээ огцом буурсан талаар мэдээ гарч, хөрөнгийн зах зээлийн индексүүд буурчээ. Харин Пүрэв гарагт АНУ-ын Сангийн сайд Стивен Мнучин БНХАУ-ын экспортын зарим бараа бүтээгдэхүүнийн гаалийн татварын хэмжээг бууруулах талаар мэдээлж, хөрөнгийн зах зээлд эерэг нөлөө үзүүлэв. Гэсэн хэдий ч үүний дараагаар тус улсын Засгийн газар тус мэдээллийг няцаасан байна.

Энэ долоо хоногт хувьцаат компаниудын 4-р улирлын санхүүгийн тайлагналын үе эхэллээ. "Reuters", "FactSet" компаниудын шинжээчид S&P 500 индексийн сагсанд багтдаг компаниудын орлогын өсөлтийн таамгын хэмжээгээ бууруулжээ. Тэдний үзэж байгаагаар 2018 оны 4-р улиралд эдгээр компаниудын ашгийн хэмжээ 2 дахин буурах төлөвтэй байна.

Европ: Европын хөрөнгийн зах зээл олон улсын хөрөнгийн зах зээлийг даган өсөлттэй хаагдлаа.

Их Британийн Ерөнхий сайд хатагтай Тереза Мэйн өргөн барьсан "Brexit" төслийг тус улсын Парламент дэмжээгүй учраас хэлэлцээр хойшлох магадлалтай байгаа аж. Хатагтай Тереза Мэй "Brexit" хэлэлцээрийн шинэ төслийг ирэх Даваа гарагт өргөн барих юм.

2018 онд ХБНГУ-ын хэрэглээ багасч, голлох салбаруудын экспортын хэмжээ буурснаар эдийн засгийн өсөлт огцом удааширчээ. 2018 онд тус улсын ДНБ 1.5%-аар өссөн нь сүүлийн таван жилийн хамгийн доод үзүүлэлт юм.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 1.5% өсч хаагдаа.

2018 оны 12-р сард Япон улсын инфляцийн түвшин 0.8%-аас 0.3% болж буурчээ. Үүнд хүнс, орон сууц болон тээврийн бүлгийн бараа бүтээгдэхүүний үнэ буурсан явдал нөлөөлөв. Тус улсын инфляцийн түвшин 2017 оны 10-р сараас хойшхи хамгийн доод хэмжээнд хүрчээ.

Японы төв банкны Мөнгөний бодлогын зөвлөлийн хуралдаан энэ сарын 22-23-ны өдрүүдэд болох юм. Тус байгууллага 2019 оны инфляцийн түвшинг 1.0 орчим хувь байхаар таамаглах төлөвтэй байна. Дэлхийн эдийн засгийн удаашрал болон газрын тосны ханш буурсан нь инфляцийн түвшний таамгийг бууруулах гол шалтгаан болсон аж.

БНХАУ: АНУ, БНХАУ хоорондын хэлэлцээрт ахиц гарна хэмээн хүлээлт үүссэнээр Хятад улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,601.66	0.33% ▲
Dow Jones	АНУ	24,706.35	2.96% ▲
S&P 500	АНУ	2,670.71	2.87% ▲
Nasdaq	АНУ	7,157.23	2.66% ▲
S&P/TSX	Канад	15,303.83	2.44% ▲
FTSE 100	Их Британи	6,968.33	0.72% ▲
S&P/ASX 200	Австрали	5,879.60	1.82% ▲
Nikkei 225	Япон	20,666.07	1.50% ▲
Hang Seng	Хонг Конг	27,090.81	1.59% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	109.02
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	97.77
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	96.77
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.03
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.78
DBM' 2023	USD	7.250%	99.62
TDBM' 2020	USD	9.375%	104.38

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.510	0.01 ▲
Libor 3M	2.760	-0.02 ▼
Libor 6M	2.850	0.01 ▲
Libor 1YR	3.030	0.02 ▲
US 2YR Bond	2.614	0.07 ▲
US 3YR Bond	2.599	0.08 ▲
US 5YR Bond	2.623	0.09 ▲
US 10YR Bond	2.784	0.08 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.01.18	Өөрчлөлт
USD	2,650.55	-0.58% ▼
CNY	391.34	-0.97% ▼
EUR	3,018.98	-1.75% ▼
RUB	39.93	0.25% ▲
KRW	2.36	-1.26% ▼
JPY	24.24	-1.50% ▼
CAD	1,998.00	-1.09% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,282.48	-0.73% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	15.31	-2.11% ▼
Зэс	USD/lb.	270.20	1.58% ▲
Нүүрс	USD/MT	101.00	3.32% ▲
WTI газрын тос	USD/bbl.	54.00	4.53% ▲
Brent газрын тос	USD/bbl.	62.93	3.96% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	3.35	1.21% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. XII	8.10%
Бодлогын хүү	2018. XII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. XI	10.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	12.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. XI	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	17.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. XI	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 49 компанийн 413.2 сая төгрөгийн 2,372,673 ширхэг хувьцаа арилжигдав.


“Ган хэрлэн” /HVB/ компанийн хувьцаа 14.89%-аар буюу хамгийн ихээр өсч 5,070 төгрөгт хүрч хаагдсан бол “Булган гурил тэжээл” /GTJ/ компанийн хувьцаа 13.60%-аар буурч 1,175 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 2,010 ширхэг үнэт цаас 205.5 сая төгрөгөөр арилжаалагдсан байна.


1-р сарын 18-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,484.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,601.66 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.33%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	618.6
Зах зээлийн үнэлгээ	2,484,769.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,601.66	0.33% ▲
MSE I индекс	9,982.67	-0.82% ▼
MSE II индекс	8,742.09	-0.45% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	1,644,019	108,641,972
Говь	268,864	91,450,318
АПУ	121,210	75,483,128
Эрдэнэ ресурс	61,052	33,419,207
девелопмент корп.		
Ард даатгал	27,568	19,690,835

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ган хэрлэн	5,070.00	14.89% ▲
Могойн гол	7,000.00	14.75% ▲
Монгол базальт	298.00	14.43% ▲
Эрчим Баян-Өлгий	650.00	8.33% ▲
Жуулчин дютти фрий	120,000	4.71% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Булган гурил тэжээл	1,175.00	-13.60% ▼
Хөвсгөл алтан дуулга	899.82	-12.55% ▼
Жинст-Увс	1,910.00	-11.98% ▼
Монгол савхи	640.00	-11.66% ▼
Хишиг Уул	550.00	-8.33% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	935,985,679
Бумбат-Алтай	195,288,477
Би Ди Сек	105,212,375
Голомт Капитал	89,062,301
Ард секьюритиз	47,857,331

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	619.00	658,728
Таван толгой	7,200.00	379,189
МИК	14,750.00	305,462
Говь	333.68	260,308
Сүү	205.17	70,578

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-09/05/19-A0242-15.995	116	11,767,620	101,050	101,840	104	15.995%
2	ZGEB-BD-10/10/19-A0336-13.945	500	50,780,000	101,250	101,870	104	13.945%
3	ZGEB-BD-14/03/19-A0219-18	294	29,799,840	100,750	101,970	104	18.000%
4	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	400	42,260,000	105,650	105,650	156	16.993%
5	ZGEB-BD-26/09/19-A0326-13.955	700	70,847,000	101,210	101,210	104	13.955%

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Түмэн шувуут” ХК-ийн үнэт цаасны захиалга хүлээн авах үйл ажиллагаатай холбогдуулан цан цохих ёслол боллоо

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Түмэн шувуут” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа 2019 оны 1-р сарын 16-ны өдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, “Түмэн шувуут” ХК-ийн Үүсгэн байгуулагч Л.Эрхэмбаяр, “Түмэн шувуут” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Болд, “Голомт Капитал ҮЦК” ХК-ийн Гүйцэтгэх захирал Мөнхжаргал нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн 5,892 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

Түмэн Шувуут компани нь анх 2004 онд 18 ажилтан, 20,000 өндөглөгч тахитайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол эдүгээ 160 гаруй ажилтан, 310,000 гаруй өндөглөгч тахитайгаар, монголын өндөг үйлдвэрлэлийн салбарын 53 хувийг дангаар гүйцэтгэж буй салбартаа тэргүүлэгч компани юм.

Тус компани нь өндөглөгч тахианы аж ахуй болон усалгаатай газар тариалан, гурил тэжээлийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх болон махны чиглэлийн тахианы аж ахуй, органик бордооны үйлдвэрийг шинээр барих зорилгоор нийт хувьцааныхаа 25 хувь буюу 5,000,000 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 200 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр ажиллаж байна. Үнэт цаасны худалдан авах захиалгыг 2018 оны 1-р сарын 15-наас эхлэн Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 1-р сарын 31-ний өдрийн 15:00 цаг хүртэл хүлээн авах юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Топ-20” индексийн сагс шинэчлэгдлээ

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын дагуу ТОП-20 индексийн багцыг 2019 онд бүрдүүлэх үнэт цааснуудыг шалгаруулж, сагсыг шинэчлэв.

2018 оны үзүүлэлтээр өмнөх сагсанд багтаж байсан 11 компани хэвээр үлдэж, “Баянгол зочид буудал”, “Шивээ овоо”, “Ариг гал”, “Адуун чулуун”, “Монголын цахилгаан холбоо”, “Шарын гол”, “Хөх ган”, “Материалимпекс”, “Улсын их дэлгүүр” ХК-иуд хасагдаж, шинээр “Хай би ойл”, “Женко тур бюро”, “Жинст-Увс”, “Айтүүлс”, “Лэндмн ББСБ”, “Монгол Базальт”, “Хөвсгөл алтан дуулга”, “Мандал даатгал”, “Ард даатгал” ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна.

Шинэчилсэн сагсын дагуу индексийн тооцооллыг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэлжээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Монгол базальт” ХК-иас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан илүүлсэн

Монголын хөрөнгийн биржид 2018 онд шинээр бүртгэгдэж олон нийтээс 6.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн “Монгол базальт” ХК нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3.6 тэрбум төгрөг буюу татан төвлөрүүлсэн хөрөнгийн 56 хувийг Үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөл, шүршдэг базальт технологийн үйлдвэр, үйлдвэрийн автоматжуулалт, механик цехийн шинэчлэлт, центрфуг бул засварын төхөөрөмж, үйлдвэрт ашиглах машин механизм, түүхий эдийн нөөц бэлтгэх, үйлдвэрийн ИТА-ын сургалт хөгжлийн төв байгуулахад зарцуулсан байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн зохицуулах хорооны мэдэгдэл

Санхүүгийн зохицуулах хороонд санхүүгийн зах зээлийн хөгжил, тогтвортой байдлыг хангах чиг үүргийг оноосон бөгөөд холбогдох хууль, тогтоомжийн дагуу Хороо үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж, зээлийн хоршооны зах зээл, эдгээр салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэн баталгаажуулж, хянан зохицуулж ажилладаг.

Хурдацтай хөгжиж буй мэдээллийн технологи, интернэт, олон нийтийн сүлжээ ашиглан өндөр хүү амлаж, иргэдээс хөрөнгө, мөнгө татах явдал цөөнгүй гарсаар байна. Тухайлбал, 2018 оноос “High Level Investment” ХХК, “Новел инвест” ХХК зэрэг байгууллага зохицуулалтгүй, хууль бус үйл ажиллагааг “эрсдэлгүй хөрөнгө оруулалт”, “даатгагдсан хөрөнгө оруулалт” гэх мэтээр сурталчлан явуулах боллоо. Холбогдох хууль тогтоомжоор “хөрөнгө оруулалтын хэрэгсэл”-ийг Хороо тогтоох төдийгүй үнэт цаас, нэгж эрх зэрэг санхүүгийн аливаа хэрэгслийг Хороо бүртгэж, зөвшөөрөл олгохоор хуульчилсан байдаг. Иймд Хорооны зохицуулалтад хамаараагүй, холбогдох зөвшөөрөл, эрх аваагүй хууль бус үйл ажиллагаагаа таслан зогсоохыг дээрх байгууллагуудад хариуцлагатайгаар мэдэгдэхийн сацуу санхүү, хөрөнгө оруулалтын аливаа хэрэгсэлд хөрөнгө оруулахдаа тусгай зөвшөөрөлтэй эсэхийг сайтар нягталж, эрх зөвшөөрөлгүй, луйврын үйл ажиллагаанд өртөж хохирохоос сэргийлэхийг нийт ард иргэддээ анхааруулж байна.

Иргэн Та өөрийн итгэл үнэмшлээр санхүүгийн аливаа үйл ажиллагаа, хэрэгсэлд хөрөнгө оруулах нь нээлттэй ч Хорооны зохицуулалтгүй, зөвшөөрөгдөөгүй хэрэгслийг сонгосон тохиолдолд ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, хохирлыг өөрөө бүрэн хариуцахыг албан ёсоор мэдэгдэж байна.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Terracom” Монгол дахь нүүрсний гарцаа жилийн 3 сая тонн болгохоор зорьж байна

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Terracom” компани 12 дугаар сард дуусгавар болж байгаа улиралд “Blair Athol” уурхайгаас 605.4 мянган тонн нүүрс борлуулсан талаар мэдээллээ.

2019 оны санхүүгийн жилийн эхний хагаст нийт нүүрсний борлуулалт нь 1.2 сая тонн болсон байна. Ингэхдээ нэг тонн нүүрсний дундаж ханш 92 ам.доллар байсан талаар тус компани мэдээллээ. Цаашид 2019 оны санхүүгийн жил дуусах үед “Blair Athol” уурхайгаас нийт 2.5 сая тонн нүүрс борлуулахаар төлөвлөж байгаа ажээ. Үүнээс гадна “Terracom” компани Монгол дахь үйл ажиллагаагаа өргөжүүлж, Монголоос гарах нүүрсний экспортоо жилийн гурван сая тонн хүргэх зорилтоо биелүүлэхээр ажиллаж байна. Мөн нэмэлт ил уурхайнууд ашиглалтад орох бөгөөд үүнд коксжих нүүрсний өөр нэг уурхай багтжээ. Ирэх хоёрдугаар сарын эхээр олборлолтоо эхлүүлнэ гэж “Terracom” компани мэдээллээ. “Terracom”-ийн хувьд Монголд Баруун Ноён уул ордоос нүүрс экспортолж байгаа юм.

Энэхүү мэдээлэлтэй зэрэгцээд Австралийн Хөрөнгийн биржид компанийн хувьцааны ханш даваа гарагт 1.52 хувиар өсч, 0.67 австрали доллар боллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn



ГЕГ: 2018 онд төмрийн хүдрийн экспорт 1.2 сая тонноор өсөж, 7.4 сая тонн болсон

Монгол Улсын төмрийн хүдрийн экспорт 2018 онд 1.2 сая тонноор өсч, 7.4 сая тонн болсон талаар Гаалийн ерөнхий газар мэдээллээ. 2018 онд 13 уурхайгаас 6.7 сая орчим тонн төмрийн хүдэр экспортлохоор батлуулсан талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээлсэн байна.

Харин үлдсэн хэсэг нь бүртгэлжээгүй экспортод тооцогдож байгаа ажээ. Гаалийн ерөнхий газрын мэдээллийг харван төмрийн хүдрийн нийт экспорт мөнгөн дүнгээрээ 28.8 сая ам.доллараар өсч, 342.2 сая ам.доллар болсон байна. Харин экспортын дундаж ханш нь өмнөх оны мөн үеэс 4.1 ам.доллараар буурч, 45.9 ам.доллар болжээ. Төмрийн бүтээгдэхүүн экспортолж байгаа гол уурхайнуудаас “Алтайн хүдэр” ХХК Таян нуур уурхайгаас 1.6 сая тонн төмрийн хүдэр экспортолсон байна. Мөн “Болд төмөр ерөө гол” ХХК Баянголын уурхайгаас гурван сая орчим тонн, Дарханы төмөрлөгийн үйлдвэр Төмөртэй, Төмөртөлгой ордоос нэг сая орчим тонн, “Монголросцветмет” Баргилтын ордоос 369 мянган тонныг экспортолжээ.

Үүнээс гадна 2019 онд төмрийн хүдрийн хоёр төсөл ашиглалтад орохоор ТЭЗҮ-ээ батлуулсан талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээлсэн юм. Эдгээр нь Дорноговь аймгийн нутагт байрлах Дарцагтын ордын зүүн хойд хэсэг орд байгаа аж. “Зэт Ди Эл” компани энэхүү төслийн хөрөнгө оруулалтыг 18.42 тэрбум төгрөг гэж ТЭЗҮ-дээ тусгасан байна. Үүнээс гадна Хэнтий аймгийн нутагт байрлах Майхан толгой орд байгаа юм. “Цахир цагаан гол” ХХК энэхүү төслийн хөрөнгө оруулалтыг 9.25 тэрбум төгрөг байхаар ТЭЗҮ-дээ тусгасан талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

TRQ: Оюутолгой үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлэв

Оюутолгой төслийн 66%-ийг эзэмшдэг “Туркойз Хилл Ресурс” (TRQ) компани 2018 оны 4-р улирлын үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа. Тус компанийн мэдээлж буйгаар өнгөрсөн оны хэмжээнд Оюутолгой уурхайн зэс үйлдвэрлэл төлөвлөсөн зорилтоос 2.6%, алтных 1.8%-иар тус тус давж биелжээ. Тодруулбал, баяжмал дахь цэвэр металын агуулгаар авч үзвэл Оюутолгойн зэсийн үйлдвэрлэл өмнөх онд 159.1 мянган тонн, алтных 285 мянган унц гэж гарчээ.

Өнгөрсөн оны сүүл улиралд алтны үйлдвэрлэл ялангуяа онцгой өсөлттэй буюу өмнөх 2017 оны 4-р улирлынхаас 234.3%-иар нэмэгдэж 117 мянган унцид хүрсэн байна. Ийнхүү алтны үйлдвэрлэл нэмэгдэхэд хүдрийн агуулга болон баяжуулах үйлдвэрийн метал авалт өссөн нь голлон нөлөөлжээ.

Гэхдээ өнгөрсөн улиралд компанийн тооцоолсончлон баяжуулах үйлдвэрт боловсруулагдах хүдрийн хэмжээ 2017 оны сүүл улирлынхаас 13.6%-иар буурсан байна. Энэ нь уурхайн 4-р үе шатны хүдэр хатуулаг өндөртэй байгаатай холбоотой байсныг компанийн мэдээнд онцоллоо.

TRQ 2019 онд Оюутолгой уурхайгаас баяжмал дахь цэвэр металын агуулгаар 125-155 мянган тонн зэс, 180-220 мянган унц алт үйлдвэрлэхээр төлөвлөсөн байна. Мөн баяжуулах үйлдвэрт орох хүдрийн нийт хэмжээ 40 сая тонн байхаар тооцсон бөгөөд өнгөрсөн онд уг үзүүлэлт 38.7 сая тоннд хүрчээ.

“Оюутолгой” компанийн 2018 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө нь /баяжмал дахь цэвэр металын агуулгаар/ 125-155 мянган тонн зэс, 240-280 мянган унц алтаар хэмжигдэж байснаас үзэхэд энэ онд алтны үйлдвэрлэлийн хэмжээ 2018 оныхоос багагүй хэмжээгээр буурахаар байна. Гэхдээ энэ оны төлөвлөгөө нь 2017 онд Оюутолгойн алтны нийт үйлдвэрлэл 114 мянган унц байсантай харьцуулахад хавьгүй өндөр дүн юм.

TRQ-ийн мэдээлж буйгаар энэ онд далд уурхайн хөндлөн нэвтрэлтийг 15-16 км-ээр урагшлуулахаар төлөвлөсөн бөгөөд уурхайн энэ оны санхүүжилтийн удирдамжийг тодорхой хугацааны дараа танилцуулах юм.

“Оюутолгой” компани өнгөрсөн оны сүүлээр уурхайн эрчим хүчний хангамжтай холбоотой “Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай” гэрээг Засгийн газартай байгуулсан билээ. Энэ хүрээнд одоо холбогдох судалгааны ажлыг эцэслэн боловсруулах ажил хамгийн чухлаар тавигдаж байна. Гэрээний хүрээнд уурхайг эрчим хүчээр хангах станцыг Тавантолгойд байгуулж, бүтээн байгуулалтыг 2020 оны гуравдугаар сард эхлүүлж, 2023 оны дундуур ашиглалтад оруулахаар тогтсон юм.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

Royal Mint: BREXIT-ийн тодорхойгүй байдал нэмэгдэж, британичуудын алт худалдан авалт өсч байна

BREXIT-тэй холбоотой тодорхойгүй байдал ихсэж байгаатай зэрэгцээд хөрөнгө оруулагчид алт худалдан авах нь нэмэгдэж байна гэж Их Британийн Төрийн өмчийн зоос үйлдвэрлэгч “Royal Mint” хэллээ. Алтны эрэлт 2018 оны эцсээс мэдэгдэхүйц өсч, өсөлт үргэлжилсээр байгаа аж. Он гарсаар алтны борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 73 хувиар өссөн байна. “Royal Mint” үйлдвэрээс ихэвчлэн хувь хөрөнгө оруулагчид алтан зоос болон гулдмай худалдан авдаг байна. Үнэт метал алтны эрэлт ийнхүү өсч байгаа нь эргэлзээгүй BREXIT-тэй холбоотой тогтворгүй байдал, мөн хөрөнгийн зах зээлийн савалгаа ихтэй байдлаас шалтгаалсан гэж “Royal Mint”-ийн Үнэ металын газрын дарга Крис Ховард хэллээ. Түүний үзэж байгаагаар алтны эрэлт цаашид ч өсөх хандлагатай байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ҮСХ: Монгол улсын эдийн засгийн 12-р сарын байдал

Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2018 оны 12 дугаар сарын эцэст 19.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 821.6 (4.4%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.6 (22.8%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2018 оны 12 дугаар сарын эцэст 968.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 73.6 (8.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 62.2 (6.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 12 дугаар сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 506.8 (3.0%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.6 (26.5%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 12 дугаар сарын эцэст 848.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 125.2 (12.9%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 25.4 (3.1%) тэрбум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувийг эзэлж, өмнөх сараас 0.9 пунктээр, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр тус тус буурсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9.2 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 9.2 их наяд төгрөгт хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2017 онд 1.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарч байсан бол 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 11.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. 2018 оны 12 дугаар сарын эцэст өмнөх сараас улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 297.6 тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 476.6 тэрбум төгрөгөөр өсчээ.

Татварын нийт орлого 8.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (30.0%) их наяд төгрөгөөр өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 577.9 (35.7%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 473.2 (29.3%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 299.5 (22.7%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 234.7 (45.2%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 170.1 (33.2%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 125.6 (21.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.5 хувийг татварын орлого, 10.2 хувийг татварын бус орлого, 6.2 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 2.1 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 79.7 хувь, хөрөнгийн зардал 17.4 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.9 хувийг эзэлж байна.

Төсвийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2018 оны эхний 11 сард урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 тэрбум америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 662.4 сая америк доллараар өсчээ.

Урсгал данс 1.5 тэрбум америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.2 тэрбум америк доллар, анхдагч орлогын данс 1.2 тэрбум америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2018 оны эхний 11 сард 76.3 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 4.4 (6.1%) сая америк доллараар өссөн байна.

Харин санхүүгийн дансны тэнцэл 1.3 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 457.4 (25.0%) сая америк доллараар буурчээ.

Нийт төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 11 сард 117.7 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 960.9 сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдаа

Монгол Улс 2018 онд нийт 156 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.0 тэрбум америк доллар, импорт 5.9 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2018 оны 12 дугаар сард экспорт 531.0 сая америк долларт, импорт 503.5 сая америк долларт хүрч, өмнөх сараас экспорт 4.9 (0.9%) сая америк доллараар буурч, импорт 7.5 (1.5%) сая америк доллараар өсчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2.3 (22.3%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 811.2 (13.1%) сая америк доллараар, импорт 1.5 (35.5%) тэрбум америк доллараар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2017 онд 1.8 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2018 онд өмнөх оноос 726.5 (39.0%) сая америк доллараар буурч, 1.1 тэрбум америк доллар болжээ. Гадаад худалдааны тэнцэл 2018 оны 12 дугаар сард 27.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 53.9 (66.2%) сая америк доллараар буурсан байна.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 12 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.6 хувиар өсч, өмнөх оны жилийн эцсээс 8.1 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.1 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 8.5 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 9.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 16.3 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 23.7 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 12 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувь, хувцас, бөс бараа, гутал болон эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ тус бүр 0.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.